



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/235

Булган

┌ Үлийн цагаан оготной тэмцэх арга ┐  
хэмжээг зохион байгуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 /б/, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/86 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Рашаант 8000 га, Дашинчилэн 8800 га, Гурванбулаг 5000 га, Могод 6000 га, Хишиг-Өндөр 5000 га, Сайхан 5000 га, Баян-Агт 3000 га буюу нийт 40800 га бэлчээрийн талбайд байгаль орчинд халгүй, энгийн механик аргаар хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг энэ оны 05 дугаар сарын 01-нээс 6 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Уг арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг сайтар хангаж, үлийн цагаан огтоно ихээр тархсан бэлчээр нутгийн малчдын хүчийг оновчтой зохион байгуулж, чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх талаар сумын Засаг дарга нартай гэрээ байгуулж, хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ч.Амгалан/-т, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Батболд/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190251